

Стандарт дахь найрсан нийлэмж нэр томьёоны бүтэц, харьцаа

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Гөрөөчингийн ГЭРЭЛМАА*

*Монгол Улс, Улаанбаатар, ШУА-ийн Хэл зохиолын
хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар*

Received: June 03, 2024

Revised: October 28, 2024

Accepted: November 04, 2024

Хураангуй: Энэ өгүүллээр бид монгол хэлний нэр томьёо бүтээхэд хамгийн өндөр давтамжтай байдаг угсруулах холбоогоор бүтсэн нийлэмж үгийн хэлбэр болох нөхцөлөөр холбогдож бүтсэн нийлэмж нэр томьёог судлан үзэв. Эдгээр нэр томьёог бүрэлдүүлэгчийн үүднээс авч үзвэл бидний судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 85 стандартын 10387 нэр томьёоны 3441 нь хоёр бүрэлдүүлэгчтэй нэр томьёо эзэлж байгаа нь 33,1%, гурван бүрэлдүүлэгчтэй нь 2611 буюу 25.14%, дөрвөн бүрэлдүүлэгчтэй нь 1446 буюу 13.92 % гэхчлэн 10-12 үгтэй нэр томьёо байх бөгөөд тэдгээр нь 0,19%-ийг эзэлж байна. Үүнээс нэрийн нийлэмж нэр томьёо нь 3243 байгаа бөгөөд харьяалахын тийн ялгалаар холбогдсон нь 1447 байгаа нь нэрийн нийлэмж нэр томьёоны 42 %-ийг эзэлж байна.

Энэ стандартчилсан нэр томьёонд хэт урт, буруу хэл зүйн хэлбэр залгаж үүссэн нэр томьёо байгааг цаашид хязгаарлах нь зүйтэй.

Түлхүүр үг: стандарт, найрсан нийлмэл нэр томьёо, бүтэц, харьяалахын тийн ялгал

Structure and relationship of compound terms in the standards

GERELMAA Guruuchin

*Department of Applied Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of
Sciences, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: The article focuses on compound terms formed with connective affixes, which are the most frequently used in the Mongolian term formation. Analyzing the

* © Г.Гэрэлмаа, 2024

Email: gerelmaag@mas.ac.mn,  <https://orcid.org/0000-0001-5316-0233>

constituents of these terms, 3,441 (33.1%) out of 10,387 terms from 85 standards consist of two components, 2,611 (25.14%) have three components, and 1,446 (13.92%) include four components. Terms with 10-12 components make up 0.19% of the total. Among these, 3,243 are noun-compound terms, with 1,447 being connected by the genitive case, accounting for 42% of the noun-compound terms. This analysis highlights the importance of reducing the use of overly long terms and those with incorrect grammatical forms in standardized terminology.

Keywords: *standard, compound terms formed by connective affixes, structure, genitive case*

1. Удиртгал

Монгол хэлэнд залгамал хэлний үндсэн хэв шинж болсон дагавраар шинэ нэр томьёо бүтээх нь түгээмэл бөгөөд идэвхтэй байсан бол одоо хоёр болон түүнээс дээш үг нийлэн задлаг хэлбэрээр буюу нийлэмж үгээр нэр томьёо бүтээх нь аль ч салбарын нэр томьёонд түгээмэл тохиолдож байна. Энэ нь аливаа зүйлийг илүү нарийн, тодорхой нэрлэх боломж нь ганц үгээр нэрлэхээс давуу талтай байдагтай холбоотой юм. Тухайлбал, “гарц” гэдэг нэг үгээр гарах боломжтой хэсэг гэсэн утга илтгэдэг бол шилжсэн утгаараа бол мухардлаас гарах санаа гэх зэргээр ойлгож болно. Харин түүн дээр “явган хүний” гэдэг үг нэмэх аваас авто замыг туулах зөвхөн явган хүнд зориулсан замыг нэрлэснээрээ илүү тодорхой нэр томьёо болдог.

Монгол хэлний нэр томьёо бүтэхэд дан үг гэхээсээ илүү хоёр болон түүнээс дээш үг нийлж бүтэх нь түгээмэл байгаа талаар эрдэмтдийн санал нийлж байна.

Монгол хэлний нэр томьёо бүтээж буй нийлмэл бүтцийн голлох хувийг нэрийн нийлэмж эзэлдэг.

Монгол хэлний нийлэмж нэр томьёоны хураангуй бүтэц нь хоёр бүрэлдүүлэгчтэй буюу дагуул + цөм гэсэн загвартай байна. Ийм загвар нь дагуул бүрэлдүүлэгчийг цөм бүрэлдүүлэгчид захируулах буюу угсруулан холбодог (управление-government) онцлогтой.

Монгол хэлний өгүүлбэрийн холбоог судалсан Л.Мишиг (1967: 44), Т.А.Бертагаев (1971: 87), Б.Рагчаа (1984: 65), Б.Пүрэв-Очир (1996: 59) нарын бүтээлд угсруулах холбоо түүний арга хэрэглүүрүүд тусгалаа олсон бөгөөд энэ холбоог нь монгол хэлний гол холбоо гэдэгтэй санал зөрсөн зүйл байдаггүй.


Угсруулах холбоо гэдгийг “... утга, үүрэг, хэл зүйн хэлбэрээрээ өөр өөр үгсийг хэлбэрийн ба утгын хувьд шууд харьцаанд оруулан, нэгийг нөгөөд нь эрхшээн захируулж, хэл зүйн тодорхой нэг арга хэрэглүүрээр холбож, харьцааны утга илтгэхийг хэлнэ” (Пүрэв-Очир 1996: 43) хэмээн бичсэн бөгөөд захирсан буюу цөм үгийг нь хэл шинжлэлийн нэр томьёоны хувьд “главный компонент”, “подчиняющее слово”, “ядро” гэхчлэн нэрлэж байгаа бол захирагдсан буюу дагуул үгийг нь “зависимый компонент”, “подчиненное слово”, “спутник-

адьюнкт” зэрэг нэр томьёотой дүйлгэн ойлгож байна.

Өгүүлбэр зүйн түвшинд хоршоо үг болон нийлмэл үг нь үгийн санжсан тогтвортой чөлөөт бус холбоо үг агаад чөлөөт холбоо үгийн нэг бүрэлдүүлэгч болно. Нийлэмж нэр томьёоны холбоо харьцаа нь гол төлөв угсруулах хэв шинжтэй байдаг бөгөөд Т.А.Бертагаев өөрийн бүтээлдээ угсруулах холбоотой нийлэмж нэр томьёог:

- Жинхэнэ нэр-тэмдэг нэр тодотголтой нэрийн нийлэмж
- Төлөөний үг тодотголтой нэрийн нийлэмж
- Тооны нэр тодотголтой нэрийн нийлэмж
- Нэр-үйлийн нийлэмж
- Дайвар үг-үйлийн нийлэмж
- Үйл- нэрийн нийлэмж
- үйл-үйлийн нийлэмж хэмээн ангилан тус бүрийн үгсийн аймаг, холбоо харьцааг буриадын аман аялгуунуудтай харьцуулан судалжээ (1971: 66-122).

Мөн эрдэмтэн Б.Пүрэв-Очир монгол хэлний нийлмэл үг нь хэлц, холбоо үг бүтэх арга загвараар бүтдэг гээд:



(1996: 115) гэж ангилжээ.

Бид судлаачдын санал дүгнэлт болон нийлэмж нэр томьёоны бүтцийн онцлогийг тусган ангиллыг хийж байна.

Нийлэмж¹ нэр томьёо гэдгийг “нийлэмж чанараар илрэх хэв шинжийг хэлнэ. Дотор нь тогтвортой нийлэмж [нийлмэл үг, хэлц], тогтворгүй нийлэмж гэж ангилан үздэг. (Гэрэлмаа, 2020: 148).

Нийлэмж нэр томьёоны хэрэглээний давтамж өндөртэй дэс дарааллын нь дагуу найрах аргаар холбогдсон нэрийн болон үйлийн нийлэмжийг тэдгээрийн арга хэрэглүүр бүрээр задлан үзэж судлав. Иймээс бидний судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 85 стандартын 10387 нэр томьёоны хэдэн хувь нь нийлэмж нэр томьёо, тэдгээр нь ямар бүтэц, холбоо харьцаатай болохыг энэхүү өгүүллээр тодорхойлох зорилготой.

¹ Хэлний түвшинд бүрд байх нийлэмж чанар нь нэр томьёо бүтээхэд адил үйлчлэх тул энэхүү нэр томьёог хэрэглэж байна.

2. Судалгааны арга зүй

Бид 85 төрлийн стандартын 10387 нэр томьёоны дотроос нийлэмж үгээр бүтсэн нэр томьёоноос нөхцөлөөр найрч холбогдсон нэр томьёог түүвэрлэн хэрэглэгдэхүүн болгов.

Энэхүү судалгаа нь хам (synchrony) цагийн судалгаанд хамаарах бөгөөд стандартуудаас баримт цуглуулж дүн шинжилгээ хийх, түүвэрлэн авсан үгсээрээ сан бүрдүүлж, хэл зүйн хэлбэр бүрийг EXCEL программ задлан ялгаж, түүнийгээ хэл шинжлэлийн задлан шинжлэх болон (analysis) нэгтгэн дүгнэх (synthesis) аргыг хэрэглэв. Түүвэрлэсэн үгийнхээ бүтэц, хэлбэрийг хувиар тооцоолох (computational) аргаар боловсруулав.

3. Найрсан угсраа нийлэмж нэр томьёо

Нэр томьёо *найрсан угсраа нэр томьёо* бүтээхэд угсруулах холбоо харьцааг Г.Гэрэлмаа “*хамжсан угсраа нэр томьёо*, гэж ангилан судалсан (2020:153)-ыг харгалзан үзэж давтамжийн байдлаар нь авч үзэхэд угсруулах холбооны найруулах арга нь давамгай байгаа учир дарааллаар нь авч үзэх болно. Монгол хэлний нэр томьёоны ерөнхий байдал нь нэрийн нийлэмж үгээр үлэмж баялаг. Нэрийн нийлэмж нэр томьёо нь бүрэлдүүлэгчийн талаасаа хоёр үгээс бүтсэн байх нь хамгийн түгээмэл бөгөөд тэдгээрийг холбоо харьцаагаар нь нэрийн найрагч буюу харьяалахын тийн ялгал болон холбох үгээр нэрийн хамжигч буюу үндсээр хамжин холбогдсон хэмээн ангилан үздэг.

Эрдэмтэн Б. Рагчаа “Орчин цагийн монгол хэлний бодит нэрийн холбоо үг” нэг сэдэвт бүтээл туурвиж, түүндээ өгүүлбэр зүйн холбооны гол хэв шинж болсон нэрийн холбоо үгийн холбох арга, хэрэглүүр, илрэх үгийн аймгийн талаар нарийвчлан судалсан судалгаа болон хэл зүйн бүтээлүүд дэх холбох ёсны судалгаа нь бидний ажлын тулгуур юм. Нэрийн найрагч холбоо үг нь нэр болон үйл үгийн аль алиныг захирч нийлэмж нэр томьёо бүтээнэ.

3.1. Нэрийн найрсан угсраа нэр томьёо

Монгол хэлэнд хоёроос дээш үгийг нэгийг нөгөөд нь захируулан холбох арга нь найруулах болон хамжуулах юм. Найруулах арга гэдэг нь захирч байгаа нэр ба үйл үгэнд өмнөх үгийг нь ямар нэгэн ил хэл зүйн хэлбэрээр холбож хэл зүйн хийсвэр утга илтгэх явдал юм.

Монгол хэлний судлалд харьяалахын тийн ялгалын нөхцөлийг хоёр үгийг холбох найрах арга хэмээн нэрлээд хэл шинжлэлийн бүтээлүүдэд тухайлбал, “Орчин цагийн монгол хэлний зүй”-д “Захирагдсан үгэнд нь аливаа тийн ялгалын зүүвэр нь тухайн холбоо хоёр үгийн хоорондох хэл зүйн харьцааны утга санааг заан илтгэдэг ийм хэлбэрийн захируулах холбоог найруулах арга гэнэ” (1966: 256) гэсэн бол эрдэмтэн Б.Пүрэв-Очир “Бидний ойлгож байгаагаар үгийг угсруулан найруулж холбох гэдэг нь нэг үгийг нөгөөд нь эрхшээн захируулж,

хэл зүйн харьцааны утга илтгэхдээ дагуул үгийг нь нэрийн ба үйлийн нөхцөлөөр эсвэл угсруулан холбох үгээр хэлбэржүүлж, цөм үгэнд нь холбохыг хэлж байна” (1994: 63) гэх зэргээр холбооны хэв шинжийг тодорхойлсон байна. Оросын эрдэмтэн Т.А.Бертагаев “...угсруулах холбоо нь хамжих, захирах хоёр аргатай. Захирах арга гэдэг нь нэг үг нөгөөгөө тийн ялгал болон захируулах үгээр холбохыг хэлнэ” гээд “Нийт шинэ нэр томьёоны 60 орчим хувь, үгийн сангийн 30 орчим хувь угсруулах холбоотой нэр томьёоноос бүрдэг” (1971: 62) гэж уг холбооны идэвхт чанарын талаар тодорхойлжээ.

Эдгээр судалгаанаас харвал, найруулах арга гэдэг нь ил бодтой хэрэглүүрээр илэрдгээрээ хамжуулах аргаас ялгаатай юм. Ил бодтой хэрэглүүрүүд нь цөм үг нь ямар үг байгаагаас хамааран, тухайлбал нэрийг нэртэй, үйлийг нэртэй холбох гэж ангилдаг бол хэрэглүүрээр нь харьяалахын тийн ялгал, тодотгон холбох нөхцөл, холбох үгээр холбосон гэхчлэн хуваадаг. Нэрийн найрагч нэр томьёоны үндсэн хэрэглүүр бол харьяалахын тийн ялгал юм.

3.1.1. Харьяалахын тийн ялгалаар холбогдсон нэрийн найрагч нэр томьёо

Нийлэмж нэр томьёоны бүрэлдэхүүнд хоёр бүрэлдүүлэгчийг харьяалахын тийн ялгалаар холбох нь хамгийн давтамжтай хэв шинж юм. Холбоо үг, өгүүлбэрийн бүтцэд орсон жинхэнэ нэр ба жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэж байгаа тэмдэг нэр, тооны нэр, тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг жинхэнэ нэр, орон цагийн нэр, захируулан холбох үгтэй холбох харьцаа заадаг шууд биш тийн ялгалыг харьяалахын тийн ялгал гэнэ. (МХС, 2022: 86) хэмээн тодорхойлж байна. Стандартчилсан нэр томьёоны дотор ч мөн түгээмэл агаад тэдгээрийг тооцоолон үзвэл, бидний судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 85 стандартын 10387 нэр томьёоны 3441 нь хоёр бүрэлдүүлэгчтэй нэр томьёо эзэлж байгаа нь 33.1% нь болж байна. Нийт хоёроос дээш бүрэлдүүлэгчтэй нэрийн нийлэмж нэр томьёо нь 3243 байна. Үүнээс харьяалахын тийн ялгалаар холбогдсон нь 1447 байгаа нь нэрийн нийлэмж нэр томьёоны 42 %-ийг эзэлж байгаа юм. Үүнийг дотор нь дараах хэв шинжид хуваан үзэж болно. Уг тийн ялгал нь -ын, -ы, -ийн, -ий, -н гэсэн зөв бичих дүрмээс хамаарсан хувилбаруудтай. Эдгээр хувилбарын дотроос -н хувилбарыг үндэс үүсэх –н -ээс ялгаж ойлгох нь чухал юм. Тухайлбал, “гинжин дамжуулагч” хэмээх нэр томьёо нь нэр үгийг тэмдэг нэрийн үүргээр хэрэглэж, дамжуулагчийн шинж чанарыг тодотгон “гинжин” хэлбэртэй болохыг нэрлэсэн бол “хоолойн бэхэлгээ” хэмээх нь хамаа харьяаны утгыг харьяалахын тийн ялгалаар илрүүлсэн хэлбэр агаад хэлбэр ижил боловч ялгаатай үүрэгтэй болох нь харагдаж байна.

а. Нэрийн найрагч нэр томьёоны бүтэц

Нийлэмж нэр томьёоны бүтцийг ярихын тулд холбоо үгтэй адилтган үзэх нь зүйтэй юм. Учир нь нийлэмж нэр томьёог бүтээгч нь холбоо үг мөн бөгөөд түүний нэг үүрэг нь “...монгол хэлний чөлөөт ба чөлөөт бус холбоо үг нь

бодит байдал, юм үзэгдэл тэдгээрийн харьцааг нэрлэх” (Пүрэв-Очир, 1999: 97) явдал юм. Холбоо үгийг бүтээж буй элементүүдийг *Бүрэлдүүлэгч гэдгийг үгээр төлөөлүүлэн үзэж ирсэн боловч үг биш бүрэлдэхүүний нэг гишүүн бөгөөд үг дангаараа байдаг бол бүрэлдүүлэгч хоёр, гурван үгээр ч бүтсэн байж болно. Жишээлбэл дутуу дунд зүйлүүд гэсэн холбоо үгийн нэгдүгээр бүрэлдүүлэгч нь дутуу дунд гэсэн хоёр үет үг, хоёрдугаар бүрэлдүүлэгч нь зүйл гэсэн үг байна* (Бертагаев, 1971: 64) гэж тодорхойлсончлон бид “бүрэлдүүлэгч”-ийг баримтлан нийлэмж үгийн бүтцийг задлан үзнэ.

Хураангуй нийлэмж нэр томьёоны бүтэц нь дагуул + цөм хэмээх ерөнхий загвартай боловч задлан үзвэл:

- а. *үг+үг*
- б. *нийлмэл үг+үг*
- *үг+нийлмэл үг*
- в. *хоршоо үг+үг*
- *үг+хоршоо*
- г. *нийлмэл үг+ хоршоо үг* гэсэн хэв маягтай байна.

Стандартчилсан нэр нэр томьёоны бүтцийг задлан үзвэл, дараах байдалтай байна. Үүнд:

- а. *үг+үг* гэсэн бүтэцтэй буюу хоёр дан үгийг холбосон хэлбэр 1363 удаа тохиолдож байна. Тухайлбал:
хэрэглэгч+ийн маягт (MNS 5242: 2003)
гааль+ийн агуулах (MNS 0515: 2015)
зөөвөр+ ийн компьютер (MNS ISO 6701-1: 2010) гэх мэт.

Мөн харь хэлээс орж ирсэн үг цөм бүрэлдүүлэгч нь болж нийлэмж нэр томьёо бүтээсэн хэлбэр ч тохиолдоно.

- хувь +ийн оператор* (MNS 5242: 2003)
даатгал+ын пломб (MNS ISO 20252: 2019) гэх мэт.

Дагуул буюу захирагдаж байгаа үг нь харь хэлээс гаралтай байх тохиолдол ч бий.

- такс+ын адилтгал* (MNS ISO 20252: 2019)
скайнер +ын уншигч (MNS ISO 20252: 2019)
фибрилляц+ын гүйдэл (MNS 0515: 2015)

- улирал+ын тариф* (MNS ISO 6701-1: 2010) зэрэг аль нэг бүрэлдүүлэгч нь

харь үг байхаас гадна хоёр харь үгийг монгол хэлний холбох нөхцөл харьяалахын тийн ялгалаар холбож нийлэмж нэр томьёо бүтээх үзэгдэл ч байна.

Жишээлбэл:

машин+ы код (MNS ISO 20252: 2019)

сканер+ын зон (MNS ISO 20252: 2019)

Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр зэрэг 323 нь нийлэмж үгийн хоёр бүрэлдүүлэгч дагуул болон цөм үгийн аль аль нь гадаад үгээр байгаа нь харьяалахын тийн ялгалаар холбогдсон нийлэмж үгийн 9.9%-ийг эзэлнэ. Энэ хоёр дан үгээс бүтсэн нийлэмж нэр томъёо нь үгийн сангийн үүднээс утгаараа салшгүй нэгдэж нийлмэл үг болтлоо хэвшин тогтсон байх нь түгээмэл байна.

б. нийлмэл үг+үг

Нийлэмж үгийн захирагдаж байгаа буюу дагуул үг нь үгийн сангийн нэг утгатай нийлмэл үг байх нь цөөнгүй байна. Жишээ нь, “*бөөний худалдаа*” хэмээх нийлмэл үгэнд “*төв*” хэмээх үг залгаж “*Бөөний худалдааны төв*” (MNS ISO 6701-1: 2010) мөн “*ашигт малтмал*” хэмээх тогтсон нийлмэл үгийг “*орд*” хэмээх үгэнд захируулан “*ашигт малтмалын орд*” (MNS ISO 6701-1: 2010) зэрэг нийлэмж нэр томъёо бүтээж байна.

в. үг +нийлмэл үг

Нийлэмж үгийн цөм буюу захирч буй үг нь нийлмэл үг байх нь цөөнгүй. Жишээ нь, “*хийн орчин*” хэмээх нийлмэл үг нь “*идэвхтэй*” гэсэн тодчилогч авснаар “*идэвхтэй хийн орчин*” (MNS 3829: 1998) гэсэн нэр томъёо бүтээжээ. Мөн хар гэрлийн шүүлтүүр (MNS 3829: 1998) нь “*гэрлийн шүүлтүүр*”-ийг “*хар*”-аар тодотгож үүсгэсэн нийлэмж нэр томъёо болно.

г. хоршоо үг+үг

Нийлмэл үгийн нэгэн адилаар нийлэмж үгийн нэгэн бүрэлдүүлэгч нь хоршоо буюу харилцан тэгш эрхтэй холбоотой боловч үгийн санд хэвшиж тогтсон үгээр байх нь түгээмэл байна. Жишээ нь: “*эрчим хүч*” хэмээх хоршоо бүрэлдүүлэгч нь “*систем*” хэмээх үгэнд захирагдан “*Эрчим хүчний систем*” (MNS 4118: 1991), мөн ойн аж ахуй байгаль орчны гүйцэтгэл (MNS ISO 6701-1: 2010) гэхэд “*аж ахуй*”, “*байгаль орчин*” гэх мэт зэрэгцүүлэх холбоогоор хоршиж бүтсэн нийлэмж нэр томъёо байна. Хоршоо үг дагуултай нийлэмж нэр томъёо:

байгаль орчны аудит (MNS ISO 6701-1: 2010)

үржил шимт хөрс (MNS ISO 6701-1: 2010) гэх мэт.

д. үг+хоршоо үг

Нийлэмж үгийн цөм үг нь хоршоо үг байж өмнөх дан бүрэлдүүлэгчээ захирсан тохиолдол байна. Жишээ нь, “*нэр төрөл*” хэмээх хоршоо үг нь өмнөө “*бараа*” хэмээх үгийг хамаа харьяаны утгаар харьяалахын тийн ялгаар захирсан

барааны нэр төрөл (MNS ISO 6701-1: 2010)

гулзайлтын бат бэх (MNS ISO 6701-1: 2010) гэх мэт.

е. холбоо үг+хоршоо үг

Захируулах холбооны үндсэн дээр бүтсэн холбоо үгийг зэрэгцүүлэх холбоотой хоршоо үгтэй харьяалахын тийн ялгалаар холбосон нийлэмж цөөвтөр байх боловч бүрэлдүүлэгчийн үүднээс авч үзвэл хоёр бүрэлдэхүүнт нийлэмж болно. Жишээ нь:

Өсгийн бэхэлгээ+ий бөх бат (MNS 0098: 1982)

Эрүүл мэнд+ийн урьдчилсан үзлэг (MNS 4118: 1991) гэх мэт.

Хүснэгт 1. Нийлэмж нэр томьёоны үгийн тоог гаргасан нь

Д/д	Нэр томьёо /үгийн тоо/	Тоо	Хувь
1	Нэг	1248	12.02
2	Хоёр	3483	33.53
3	Гурав	2611	25.14
4	Дөрөв	1446	13.92
5	Тав	738	7.11
6	Зургаа	410	3.95
7	Долоо	298	2.87
8	Найм	81	0.78
9	Ес	41	0.39
10	Арав	12	0.12
11	Арван нэг	10	0.10
12	Арван хоёр	8	0.08
13	Арван гурав	1	0.01
Нийт		10387	100.00



Зураг 1. Нийлэмж нэр томьёоны бүтцийг хувиар тооцоолон үзүүлсэн байдал

б. Нэрийн найрагч нэр томьёоны утга

Нэрийн найрагч нэр томьёоны дотор хамгийн давтамж өндөртэй нь харьяалахын тийн ялгалаар хэлбэржсэн нийлэмж нэр томьёо юм. Хоёр бүрэлдүүлэгчийг харьяалахын тийн ялгалаар холбохдоо захирч буй бүрэлдүүлэгчийг дэлгэрүүлсэн хэд хэдэн хийсвэр утга илтгэдэг байна. Харьяалахын тийн ялгал нь дэлхийн олон хэлэнд түгээмэл холбох хэрэглүүр агаад “нэр үг болон төлөөний үгэнд залгаж өмчлөл, хэмжилт, холбоо, эх сурвалж заасан утга илтгэдэг, англи хэлэнд нэр үг болон төлөөний үгийн ард -’s нөхцөл залгаж энэ утгыг илэрхийлнэ.” (<https://www.thoughtco.com/genitive-grammatical>)” гэсэн нь ут тийн ялгалын утгын талаар өгүүлжээ.

Монгол хэлний харьяалахын тийн ялгалаар холбогдсон нийлэмж үг хамгийн өндөр давтамжтайн зэрэгцээ хэл зүйн олон утга илтгэдэг ч нэг хэл зүйн хэлбэрээр илэрдэг онцлогтой.

Стандартчилсан нэр томьёоны сан дотор хоёр нэрийг харьяалахын тийн ялгалаар холбосон нийлэмж үгийг утгыг давтамжийн талаас нь ангилж үзвэл:

- а. Стандартчилсан нэр томьёонд үүрэг, зориулалтын үүднээс нэрлэсэн нийлэмж нэр томьёо хамгийн давтамжтай байна. Тухайлбал; хоршоологчид бүтээгдэхүүнээ зарах дэлгүүрийг “*хоршооллын дэлгүүр*” (MNS 0515: 2015) гэж зориулалтаар нь нэрлэсэн бол үүнтэй адил нийлэмж нэр томьёо

гааль+ын хяналт (MNS 0515: 2015)

гал+ын шат (MNS 0515: 2015)

зөөвөр+ийн гал унтраагуур (MNS 0639: 2016)

эрүүл мэнд+ийн үзлэг (MNS 4967: 2000)

гэр+ийн шаахай (MNS 3843: 1985) гэх мэт.

- б. Хамаа харьяаг заасан утгатай нийлмэл нэр томьёо стандартад түгээмэл байна. Захирч буй үгийг юунд хамааралтай болохыг заасан нэр томьёо:

барилга+ын гэрээ (MNS 5242: 2003)

хээ+ий товруу (MNS 3028: 1981)

хөрс+ий үржил шим (MNS 5914: 2008)

ноос+ы төрөл (MNS 3362: 1982) гэх мэт.

- в. Бүхэл болон хэсгийн утгатай нийлмэл нэр томьёо нь тухайн зүйлийг илүү тодорхой нарийвчлан зааж үүсгэсэн хэлбэр юм. Сэнс гэхэд юуны хэсэг болохыг илтгэхийн тулд “*нисэх онгоцны*” гэдгээр тодотгох жишээтэй. Жишээ нь:

дээл+ийн дотор (MNS 3843: 1985)

скайнер+ын уншигч (MNS ISO 20252: 2019)

материал+ын нягт (MNS ISO 6701-1: 2010) гэх мэт.

- г. Тухайн зүйлийн орших орныг заасан утгатай дараах нэр томьёо байна.

Жишээ нь:

ул+ы үлдэгдэл (MNS ISO 3877-1: 2014)

газар+ын тос (MNS ISO 3877-1: 2014) гэхэд “үлдэгдэл” нь уланд байхыг, “тос” нь газарт байрлахыг заасан нийлэмж нэр томьёо бүтээнэ.

- д. Улирал болоод цаг хугацааны утгата нийлэмж нэр томьёо нь
Ойрын харилцаа холбоо (MNS ISO 6701-1: 2010)
Байнгын сайжруулалт (MNS ISO 6701-1: 2010) гэх зэргээр “*ойрын*”,
“*байнгын*” зэрэг нь орон зайн болоод цаг хугацааны утга илтгэж нийлэмж
үгийн бүрэлдүүлэгч болно.

3.1.2. Тодотгон холбох нөхцөлөөр холбогдсон нэрийн найрагч нэр томьёо

Монгол хэлний судлалд үйл үгийг нэр үгтэй холбож нэгэн цогц нэрлэлт үүсгэдэг хэл зүйн хэлбэрийн талаар бичсэн судалгааны бүтээлүүдийг юун түрүүнд авч үзэх нь зүйтэй.

Энэхүү хэрэглүүрийг судлаачид “үйлт нэр” (ОЦМХ, 1966: 153), “цагт нэр”, “тэмдэг үйл”, “үйлийн нэр”, “тодотгон холбох нөхцөл” (Бямбасан, 1987: 104; ОЦМХҮЗБ, 1987: 86; Өнөрбаян, 2004: 269; Мөнх-Амгалан, 2014: 192-208) гэхчлэн янз бүрээр нэрлэж ирсэн боловч одоо ерөнхий боловсролын дунд сургуулийн сурах бичиг зэрэгт “тодотгон холбох нөхцөл” гэдэг нэр томьёог голлон хэрэглэж байна.

Эдгээр нөхцөл нь:

- а. Өнгөрсөн цаг -сан, -сэн, -сон, -сөн
- б. Одоо цаг -аа, -ээ, -оо, -өө, -даг, -дэг, -дог, -дөг
- в. Ирээдүй цаг -х, -маар, -мээр, -моор, -мөөр, -хуйц, -хүйц, -гч

зэрэг бүлэг нөхцөл юм.

Харин монгол хэлний нэр томьёог судалсан Т.А.Бертагаев нөхцөл үйлийн нөхцөлтэй нийлэмж үгийг “үйлийн-нэршсэн холбоо үг” гэж нэрлээд “нийт нэрийн холбоо үгийн бараг 20 орчим хувийг энэ холбоо үгээр бүтсэн нэр томьёо эзэлнэ” (1971: 96) гээд тус бүрээр нь жишээ татан тайлбарлажээ.

“-х” нөхцөлөөр найрсан нийлэмж

Монгол хэлний судлалд ирээдүй цагаар тодотгон холбох “-х” нөхцөл гэж нэрлэгдсээр ирсэн энэхүү бүтээврийн нэг үүрэг нь холбоо үгийн түвшинд хоёр үгийг холбож нэр томьёо бүтээх явдал бөгөөд ижил төрлийн бусад нөхцөлөөсөө илүү идэвхтэй шинжтэй байна.

Судалгааны бүтээлд “үйл үгийн тодотгон холбох -х, -даг (-дэг, -дог, -дөг) нөхцөлөөр нэр үгэнд захируулан холбож найрсан угсраа нэр үг бүтээнэ. Жишээлбэл: шинжлэх ухаан, унадаг дугуй” (ОЦМХ, 2012: 123) гэжээ.

Үүнийг тухайн бүтээврээр холбогдсон нийлмэл нэр томьёоны давтамжаас харвал 120,000 үгтэй “Орос - монгол нэр томьёоны толь”-ийн I ботид 842, II ботид 1268, III ботид 1147, нийт 3250 удаа давтагдсан тоогоор тохиолдож байгаа нь -х бүтээврийн нийлмэл үг бүтээх чадвар нь жирийн үгийн сангаасаа тусгай мэргэжлийн үгийн санд давуу байгааг илтгэж (Гэрэлмаа, 2020: 186) байдагчлан стандартчилсан нэр томьёоны бүтцэд “-х” -ээр холбосон нийлэмж нэр томьёо 298 удаа тохиолдоно.

цийдмэгжүүл+х хугацаа (MNS ISO 6701-1: 2010)

шүүрүүл+х хоолой (MNS 5350: 2003) гэх зэрэг хоёр дан үгээс бүтсэн нийлэмж байхаас гадна

ачаа бэхлэ+х төхөөрөмж (MNS 3474: 2003)

эдэлгээ даа+х чадвар (MNS 5086: 2001) гэх зэргийн “*ачаа бэхлэ-*”, “*эдэлгээ даа-*” зэрэг холбоо үгэнд “*-х*” нөхцөл залган нийлэмж нэр томъёо бүтээнэ. Энэ тохиолдолд “*-х*” нөхцөл цагийн харьцааны утга илтгэхгүй гол төлөв зориулалтын утга илтгэнэ. Жишээ нь:

*-сан*⁴ нөхцөлөөр найрсан нийлэмж нэр томъёо 188 удаа тохиолдож байна. Тухайлбал:

тулга+сан холболт (MNS ISO 6701-1: 2010)

эрдэсжүүл+сэн зурвас (MNS ISO/TS 19104: 2012)

цөмөр+сөн гэмтэл (MNS 3028: 1981)

зэрэг дан бүрэлдүүлэгчтэй нийлэмж нэр томъёо байхаас гадна аль нэг бүрэлдүүлэгч нь холбоо үг байгаа нийлэмж үг

захал+сан зүсмэл материал (MNS ASTM E 284: 2008)

үргэлжил+сэн багц давхарга (MNS ISO 1998-4: 2008) гэх мэт.

*-даг*⁴ нөхцөлөөр найрсан нийлэмж нэр томъёо 18 удаа тохиолдоно. Жишээ нь:

хөв+дөг кран (MNS ISO 6701-1: 2010)

шилж+дэг хэв (MNS ISO/TS 19104: 2012) гэж дан бүрэлдүүлэгчийг холбох буюу

хөөрөгдөж хэрэглэ+дэг хөвөн (MNS ISO 3880: 2002)

өрж хураа+даг кран (MNS 3474: 2003) гэж “*хөөрөгдөж хэрэглэ*”, “*өрж хураа*

зэрэг үйлийн холбоо үгийг цөм бүрэлдүүлэгчид захируулан нийлэмж нэр томъёо бүтээнэ.

*-аа*⁴ нөхцөлийн зөвхөн -аа хувилбараар нь холбогдсон нийлэмж 3 удаа тохиолдож

замд яв+аа ачаа (MNS 3474: 2003)

хадгалалтад бай+аа илгээмж (MNS ISO 6701-1: 2010) гэсэн жишээ байгаа бөгөөд үүнтэй адил цөөн тохиолдож буй -хуйц нөхцөл 1 үг 2 удаагийн давтамжтай байгаа нь

мэдэгд+хүйц нөлөөлөл (MNS 5242: 2003) Нягтлан бодох бүртгэлийн нэр томъёо

Тодотгон холбох нөхцөлийн нэг араас үгүйсгэх утгатай -гүй хэлбэрт залгасан тохиолдол үгийн бүтцэд тохиолдож байна. Жишээ нь:

аа +гүй угаагдаагүй давирхай (MNS ISO 3877-1: 2014)

х +гүй норохгүй шинж (MNS 5085: 2001)

даг+гүй эргэдэггүй кран (MNS ISO 6701-1: 2010) зэрэг хэлбэр 12 удаа тохиолдоно.

Харин стандартчилсан нэр томьёоны бүтцэд шиг мэт, адил, тухай, төлөө зэрэг холбох үгийн тусламжтайгаар нийлэмж нэр томьёо бүтээсэн нь бидний хэрэглэгдэхүүнд тааралдсангүй учир хэрэглээний давтамж цөөнтэй хэмээн үзэж болох юм.

3.2. Үйлийн найрсан угсраа томьёо

Монгол хэлний нэр томьёоны бүтцэд үйл нэр томьёо тун цөөн бөгөөд гол төлөв нэр үгээр нэр томьёо тогтоохыг чухалчилсаар ирсэн. Энэ байдал нь нэгээс дээш бүрэлдүүлэгчтэй нийлэмж нэр томьёонд ч уламжлагдсан юм. Нийлэмж нэр томьёоны захирч байгаа нь үйл үг байвал үйлийн нийлэмж хэмээн нэрлэх бөгөөд стандартчилсан нэр томьёонд ийм бүтэц харьцангуй олон тохиолдож байна. Үйлийн нийлэмж нь найрах болон хамжих аргаар холбогдоно.

3.2.1. Нэр - үйлийн найрагч нийлэмж нэр томьёо

Монгол хэлний өгүүлбэр зүйн холбооны нэгэн хэв шинж болох дагуул үг нь үйл үгээр бүтсэн холбоо нь нийлэмж нэр томьёоны бүрэлдэхүүнд багтана. Үйлийн найрагч нэр томьёо нь нэр болон үйл үгийг захирч нийлэмж үүсгэнэ.

Нэр үгийг үйл үгэнд заах, гарах, үйлдэх, хамтрах, чиглэхийн тийн ялгалаар найруулан холбож нийлэмж нэр томьёо бүтээх боломжтой боловч хэрэглээнээс хамаарч зарим тийн ялгалаар холбосон нийлэмж нэр томьёо тааралдахгүй байна.

Хамгийн гол холбоо нь *заахын тийн ялгал* бөгөөд “холбоо үг, өгүүлбэрийн доторх жинхэнэ нэр ба жинхэнэ нэрийн үүргээр орсон тэмдэг нэр, тооны нэр, тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг тусах үйл үгтэй шууд холбох тийн ялгалыг заахын тийн ялгал гэнэ” (МХС, №9 Үг зүй, 2022: 86) хэмээн тодорхойлж байна.

Өмнөх үгээ заахын тийн ялгалын ил хэлбэрээр буюу -ийг, -ыг, -г, мөн тэг (0) хэлбэрээр холбож нийлэмж нэр томьёо бүтээдэг 2 хэв маяг байна. Бидний хэрэглэгдэхүүнд заахын тийн ялгалын -ийг, -ыг, -г буюу ил хэлбэрээр холбосон нийлэмж үг нийт 130 удаа

хүчдэл+ийг сэргээх (MNS 3635: 1983)

хөрс+ийг сэндчилэх (MNS ISO/TS 19104: 2012)

бутан+ыг ялгах (MNS ISO 1998-1: 2008) гэх зэргээр тохиолдоно.

Заахын тийн ялгалын 0 хэлбэрээр хэлбэржсэн 74 тохиолдоно.

байришил+0 тогтоогч (MNS 0515: 2015)

үйлчилгээ+0 үзүүлэх (MNS 5242: 2003) гэх мэт.

Заахын тийн ялгалыг далд хэлбэрээр хэлбэржүүлэх нь ялгах ба үл ялгахын ёстой хамаатай бөгөөд үүнийг “... тэг [0] хувилбар нь төрлийн олон юмнаас үл ялгасан тусагдахуун, мөн заахын тийн ялгалаар хэлбэржсэн зэрэгцсэн гишүүдийн эцсийн бус гишүүдэд тохиолдоно” (ОЦМХ, 1997: 229) гэжээ.

Заахын тийн ялгалын ил хэлбэрээр хэлбэржүүлснийг төрлийн олон юмнаас ялгасан тохиолдолд хэрэглэх бөгөөд нийлэмж нэр томьёонд тун цөөн 5% орчим хувийг эзэлнэ. Заахын тийн ялгалын дараа давтамжаараа үйлдэх, өгөх орших, гарахын тийн ялгал үйлийн нийлэмж нэр томьёо бүтээж, чиглэх, хамтрахын тийн ялгал нийлэмж нэр томьёо бүтээхэд төдийлөн бүтээлч биш байна. Үйлдэхийн тийн ялгал нь “холбоо үг, өгүүлбэрийн бүтэц дэх жинхэнэ нэр ба жинхэнэ нэрийн үүргээр орсон тэмдэг нэр, тооны нэр, тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг үйл үгтэй холбох шууд тийн ялгалыг хамтрахын тийн ялгал” (МХС, №9 Үг зүй, 2022: 91) хэмээнэ.

Үйлийн нийлэмж

хаяг +аар хүргэх (MNS 0515: 2015)

автомат+аар баглах (MNS ISO 6701-1: 2010)

бусад+аар гүйцэтгүүлэх (MNS 5242: 2003) зэрэг нэр томьёо 16 удаа

тохиолдоно.

Өгөх оршихын тийн ялгал нь “холбоо үг, өгүүлбэрийн доторх жинхэнэ нэр ба жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэж байгаа тэмдэг нэр, тооны нэр, тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг үйл үг, тэмдэг нэртэй холбох шууд биш тийн ялгал (МХС, №9 Үг зүй, 2022: 88) юм.

Үйлийн нийлэмж нэр томьёог “-д” хэлбэрээр холбосон.

зуух+д хатаах (MNS 6777: 201)

харанхуй+д дасах (MNS ISO 6701-1: 2010)

талбай+д угсрах (MNS ISO 9229: 2010)

зуух+д хатаах (MNS 6777: 2019) гэх зэрэг 8 удаа тохиолдоно.

Гарахын тийн ялгал нь “холбоо үг, өгүүлбэрийн бүтэц дэх орсон жинхэнэ нэр ба орон цагийн нэр, жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэсэн тэмдэг нэр, тооны нэр, тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг тэмдэг нэртэй холбох шууд биш тийн ялгал юм” (МХС, 2022: 90).

Үйлийн нийлэмж нэр томьёог “-аас⁴” хэлбэрээр холбож бүтээсэн

эрсдэл+ээс зайлсхийх (MNS 0515: 2015)

төлбөр+өөс чөлөөлөх (MNS ISO 20252: 2019)

зэрэг нэр томьёо хамгийн цөөн буюу 6 удаа тохиолдоно.

Стандартчилагдсан нэр томьёоны дотор хэл зүйн хэлбэрээр оруулж болохыг үгээр илэрхийлсэн “элэгдэлд нэрвэгдэж болзошгүй газар” (MNS 4118: 1991) гэхийг нөхцөлөөр хураангуйлж “элэгдэж болзошгүй газар” гэх буюу тодотгогч гишүүнийг буруу байрлуулсан “Химийн аюултай бодис алдагдах” (MNS 4118: 1991) гэдгийг задлан үзвэл, “бодис алдагдах” гэсэн ерөнхий утгад “бодис”-ыг тодотгож байгаа үг нь “химийн” болон “аюултай” хэмээх хоёр өөр тодотгол юм. Гэтэл утгаа “химийн бодис” гэж тогтсон нийлмэл үгийн хооронд “аюултай” гэдэг үг оруулснаар “химийн аюултай” хэмээх утга зүйн алдаатай холбоо үг үүсгэж байна. Учир нь химийн бодис бүхэн аюултай биш бөгөөд “аюултай химийн бодис алдагдах” гэж найруулбал утга, хэлбэрийн хувьд зөв нийлэмж нэр томьёо болно.

5. Дүгнэлт

Судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 85 стандартын 10387 нэр томьёоны сангаа хэл зүйн арга, үгийн тоогоор нь тэмдэглэн EXEL файл үүсгэн тус бүрээр тооцоолон судлаад дараах дүгнэлтийг хийв.

1. Стандартчилсан нэр томьёо үгийн бүтцийн үүднээс авч үзвэл дан үгээс илүү нийлэмж үгээр голлон оноосон байна.
2. Нийлэмж нэр томьёоны урт нь харьцангуй их буюу 1-12 үгээс бүтсэн нийлэмж нэр томьёо байв.
3. Үйлийн нийлж нэр томьёо стандартад харьцангуй олон тоотой байгаа нь үйл явцыг нэрлэн заах онцлогоос хамаарч байна.
4. Нийлэмж нэр томьёог голлон бүтээгч нь нэрийн нийлэмж бөгөөд түүний хэл зүйн хэлбэр харьяалахын тийн ялгал юм. Иймээс 3243 нэрийн нийлэмж нэр томьёоны харьяалахын тийн ялгалаар холбогдсон нь 1447 байгаа бөгөөд нэрийн нийлэмж нэр томьёоны 42 %-ийг эзэлж байгаа юм.
5. Харьяалахын тийн ялгалын голлох утга хамаа харьяаны утга хэмээн өмнөх судалгааны бүтээлд дурдсан боловч стандартчилагдсан нэр томьёонд үүрэг, зориулалтын утга давамгайл байна.
6. Тодотгон холбох -х,-сан⁴ -аа⁴ нөхцөл нэр томьёо бүтээхэд идэвхтэй оролцдог бол -хуйц, -маар нөхцөлтэй нийлэмж үг тохиолдохгүй байгаа нь нэр томьёо бичгийн хэлний үндсэн шинжийг агуулдагтай холбогдоно. Үүнтэй адил нөхцөл бол хамтрах болон чиглэхийн тийн ялгалаар нийлэмж нэр томьёо бүтээхгүй байгаа явдал юм.
7. Стандартчилсан нэр томьёоны бүтцэд 12 хүртэл үгээр тогтоосон нэр томьёо байгаа нь үгчлэн орчуулж утга санааг хураангуйлаагүйн дээр нэр томьёоны нэрлэх шинж чанарыг алдагдуулж байна.

Ном зүй

- Бертагаев, Т.А.** (1974). *Лексика современных монгольских литературных языков*. М., 382 с. [Lexicon of Modern Mongolian Literary Languages. М., 382]
- Гэрэлмаа, Г.** (2020). *Монгол хэлний нэр томьёо бүтэх задлаг болон нийлэг хэл шинж*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G. *Mongol helnii ner tomiyo bütekh zadlag bolon niileg hev shinj* [Analytic and synthetic methods of creating terms in Mongolia]. Ulaanbaatar: Soyombo printing. 2020.]
- Мишиг, Л.** (1957). *Монгол хэлний холбоо үгийн зүйл*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Mishig, L. *Mongol helnii holboo ügiin züil* [Category of compound in Mongolian]. Ulaanbaatar, Soyombo printing, 2020.]
- МХС-** *Монгол хэл судлал, №9 Үг зүй, [Mongol hel sudlal. [Study of Mongolian language. Ulaanbaatar, Soyombo printing, 2020.]*

- Мөнх-Амгалан, Ю., Кан Шин.** (2014). *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал II*. Улаанбаатар: Соёмбо. [*Orchin tsagiin mongol helnii buteever sudlal* [Morphology of Modern Mongolian]. Ulaanbaatar: Soyombo printing. 2014.]
- ОЦМХ** (1966). *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар. [*Orchin tsagiin mongol hel*. Modern Mongolian Language. Ulaanbaatar, 1966.]
- Өнөрбаян, Ц.** (1994). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар. [*Orchin tsagiin mongol helnii üg zui*. [Modern Mongolian Morphology]. Ulaanbaatar. 1994.]
- Пүрэв-Очир, Б.** (1996) *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй II*. Улаанбаатар [*Orchin tsagiin mongol helnii ogүүлber zui*. Syntax of Modern Mongolian. Ulaanbaatar, 1996.]
- Рагчаа, Б.** (1984) *Монгол хэлний бодит нэрийн холбоо үг*

Цахим холбоос

<https://languages.oup.com/google-dictionary-en/>

<https://masm.gov.mn/d>

<https://dl.acm.org/doi/pdf/10.1145/53990.54009#:~:text=Grammatical%20abstraction%20is%20defined%20as,%E2%80%9Cmore%20abstract%E2%80%9D%20than%20another.>

[https://www.thoughtco.com/genitive-grammatical-case-1690887#:~:text=The%20genitive%20case%20\(or%20function,of%20phrase%20after%20a%20noun.](https://www.thoughtco.com/genitive-grammatical-case-1690887#:~:text=The%20genitive%20case%20(or%20function,of%20phrase%20after%20a%20noun.)

Стандарт

MNS 3472: 1983 *Газар тариалан стандарт*

MNS 3474: 2003 *Ургамал хамгаалал стандарт*

MNS 0515: 2015 *Шуудан холбоо*

MNS 0639: 2016 *Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо*

MNS 5242: 2003 *Нягтлан бодох бүртгэлийн нэр томъёо*

MNS ISO 20252: 2019 *Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр томъёо*

MNS ISO 6701-1: 2010 *Барилга ба иргэний барилга байгууламж*

MNS 0639: 2016 *Галын тоног төхөөрөмж, гал унтраах багаж хэрэгсэл*

MNS 4967: 2000 *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй*

MNS 3843: 1985 *Илгэн ба үслэг нэхий хувцас*

MNS 3028: 1981 *Шүдэнзний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн ба хагас боловсруулсан бүтээгдэхүүн*

MNS 5914: 2008 *Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.*

MNS 3362: 1982 *Нэхмэл ба арьс ширний технологи*

MNS ISO 3877-1: 2014 *Резин дугуй, хийлэх хошуу болон дотуур хаймар*

MNS 5350: 2003 *Цахилгаан станц. Цахилгаан шугам сүлжээ*

MNS 5086: 2001 *Зуухны эд анги, хэсэг, Эрчим хүч ба дулаан дамжуулах техник*

MNS ISO/TS 19104: 2012 Газар зүйн мэдээлэл.Мэдээллийн технологи албан ажлын техник хэрэгсэл


MNS ASTM E 284: 2008 Авто зам.Үзэгдэх байдлын нэр томъёо, тодорхойлолт

MNS ISO 1998-4: 2008 Газрын тосны аж үйлдвэр, Боловсруулалт

MNS 0098: 1982 Гутал Чанарын суурь үзүүлэлт

MNS 4118: 1991 Хөдөө аж ахуй. Ойн аж ахуй

MNS 6777: 2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.